




**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО**

ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧИЙН СТАТИСТИК МЭДЭЭНИЙ МАЯГТ, ЗААВАР

Улаанбаатар 2024 он





ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО
Зах зээл, үнэ тарифын зохицуулалтын газар
Судалгаа шинжилгээний хэлтэс
Утас: 11-304258

ӨМНӨХ ҮГ

Харилцаа холбооны зохицуулах хороо нь харилцаа холбооны салбарт тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс нийт 16 маягтын дагуу хагас жил, жилийн эцсийн тайлан мэдээ авч, харилцаа холбооны үйлчилгээний талаарх статистик, зах зээлийн мэдээллийг өөрийн вэб хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлдэг.

Тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс статистик, тайлан мэдээ авах нь зах зээлийн өрсөлдөөний нөхцөл байдал, давамгайл үйлчлэгчийг тодорхойлох, зохицуулалтын баримт бичгүүдийг боловсруулах, шийдвэр гаргахад суурь мэдээллээр хангах, тусгай зөвшөөрлийн гэрээ, нөхцөл шаардлагын хэрэгжилт буюу үйлчилгээний чанарыг хянах, үнэлэх үндсэн зорилгыг агуулдаг.

Харилцаа холбооны сүлжээ, үйлчилгээний талаарх суурь мэдээллийг олон нийтэд мэдээлснээр харилцаа холбооны салбарын хөгжлийг тодорхойлох, бодлогын зорилтуудыг хэмжих, улмаар Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэмжихэд шаардлагатай мэдээллээр холбогдох төрийн болон олон улсын байгууллагуудыг хангах, зах зээлд оролцогч талуудыг буюу тусгай зөвшөөрөл эзэмшигчид, хөрөнгө оруулагчид, зах зээлд шинээр нэвтрэгчдийг зах зээлийн холбогдох мэдээллээр хангахад чухал ач холбогдолтой юм.

Тайлан мэдээний маягтыг анх Үндэсний статистикийн хорооны даргын 2006 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 01/121 тоот тушаал болон ХХЗХ-ны даргын 2006 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 146 тоот тушаалуудаар баталж, 2014, 2017 онуудад тус тус нэмэлт өөрчлөлт оруулж байсан.

Салбарын хууль, эрх зүйн хэм хэмжээний актуудад сүүлийн 3-4 жилд өөрчлөлтүүд орсноос гадна харилцаа холбооны үйлчилгээ, технологи хурдтай өөрчлөгдөж байгаа, Олон улсын цахилгаан холбооны байгууллагад (ITU) хүргүүлдэг мэдээлэл шинэчлэгдсэн, түүнчлэн үзүүлэлтийн агуулга, ойлголтыг тодорхой болгох, арга зүйгээр хангах, зарим шаардлагагүй үзүүлэлтийг хасаж, давхардлыг арилгах, цахим системд уялдуулах зэрэг хэрэгцээ шаардлагууд бий болсон. Иймд тус хорооноос 2023 онд нийт 8 маягтыг шинэчлэн боловсруулж, Статистикийн тухай хуулийн 19-р зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэн Үндэсний статистикийн хорооноос (ҮСХ-ны даргын 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн А/31 тоот тушаалаар) зөвшөөрснөөр,



Харилцаа холбооны зохицуулах хорооны даргын 2024 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн А/93 тоот тушаалаар баталсан. Үүнд:

1. Харилцаа холбоо - Суурин холбооны үйлчилгээ эрхлэгчийн мэдээний маягт (З-ХХ-СХУ), маягт нөхөх заавар;
2. Харилцаа холбоо-Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгчийн мэдээний маягт (З-ХХ-ҮХУ), маягт нөхөх заавар;
3. Харилцаа холбоо - Суурин интернэтийн үйлчилгээ эрхлэгчийн мэдээний маягт (З-ХХ-СИУ), маягт нөхөх заавар;
4. Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн мэдээний маягт (З-ОСДУ), маягт нөхөх заавар;
5. Телевизийн үйлчилгээ эрхлэгчийн мэдээний маягт (З-ТВУ), маягт нөхөх заавар;
6. Төлбөртэй телевизийн үйлчилгээ эрхлэгчийн мэдээний маягт (З-ТТВУ), маягт нөхөх заавар;
7. Радиогийн үйлчилгээ эрхлэгчийн мэдээний маягт (З-РҮ), маягт нөхөх заавар;
8. Шуудангийн үйлчилгээ эрхлэгчийн мэдээний маягт (З-ШҮ), маягт нөхөх заавар;

Тусгай зөвшөөрөл эзэмшигчид жилийн эцсийн тайланг жил бүрийн 2-р сарын 20-ны дотор, хагас жилийн тайлан 8-р сарын 1-ний дотор ирүүлэх үүргийг тусгай зөвшөөрлийн гэрээ болон “Харилцаа холбооны зах зээлд шударга өрсөлдөх нөхцөл бүрдүүлэх журам”-ын дагуу хүлээдэг ба тайлан мэдээг 2019 оноос цахим хэлбэрт шилжүүлж www.statistic.crc.gov.mn системээр дамжуулан авч байна.

Энэхүү гарын авлагыг тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд зориулан эдгээр шинэчлэн батлагдсан маягтуудыг, түүнийг нөхөх зааврын хамт нэгтгэн оруулсан болно. Мөн цахим системд нэвтрэх зааврыг тусгасан.

ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИЙН МЭДЭЭНИЙ (3 - ШҮ) МАЯГТ

3-ШҮ

Үндэсний статистикийн хорооны даргын 2024 оны А/31 дугаар тушаалын 8 дугаар хавсралтаар зөвшөөрснөөр, Харилцаа холбооны зохицуулах хорооны даргын 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/93 тоот тушаалын Наймдугаар хавсралтаар батлав.

Монгол Улсын “Байгууллагын нууцын тухай” хуулийн 5 дугаар зүйлийн 2, “Статистикийн тухай” хуулийн 22 дугаар зүйлийн 3 дугаар заалтын дагуу мэдээллийн нууцыг чандлан хадгална.

ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧИЙН МЭДЭЭ

Он _____ (хагас жил/жилийн эцэс)

I. ХАЯГИЙН ХЭСЭГ

Регистрийн дугаар							
Аж ахуйн нэгж, байгууллагын нэр							
Байршил	Нэр						Код*
Аймаг, нийслэл							
Сум, дүүрэг							
Баг, хороо							
Гудамж, хороолол							
Байшин, байр							
Хашаа, хаалганы дугаар							
Бүсчлэлийн код							
Цахим хуудас							
Байгууллагын утасны дугаар							
Байгууллагын цахим шуудангийн хаяг							
Хариуцсан ажилтны: Овог, нэр							
	Албан тушаал						
	Утасны дугаар						
	Цахим шуудан						

Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллага нь жилийн мэдээг 02 дугаар сарын 20-ны өдрийн дотор, хагас жилийн мэдээг 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор ХХЗХ-ны цахим программд шивж дамжуулна.

Код*-з маягт нөхөх заагараас харна уу.

II. ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

ҮЗҮҮЛЭЛТ	Ангилал, код	Мөрийн дугаар	Нууцын зэрэг	Хэмжих нэгж	Дүн	Тайлбар
А		Б	В	Г	1	2
1. САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД						
Дүрмийн сангийн хэмжээ мөр 1=мөр (2+6)						
Дүрмийн сан, өмчийн хэлбэрээр	Төрийн	10	2	Н1	мянган төгрөг	
	Орон нутгийн	20	3			
	Хувийн, Монгол Улсын	51	4			
	Хувийн, гадаадтай хамтарсан	53	5			
	Гадаад улсын	52	6			
Нийт орлого мөр 7 = мөр (8+15)		7				
Орлого, үйлчилгээний төрлөөр	Бичиг захидал	8				
	Боодол	9				
	Илгээлт	10				
	Буухиа шуудан	11				
	Хэвлэл захиалга (ном, сонин, сэтгүүл)	12				
	Марк, үнэт цаасны борлуулалт	13				
	Хүргэлт	14				
Бусад	15					
Нийт хөрөнгө оруулалт мөр 16=мөр (17+22)		16				
Хөрөнгө оруулалт, эх үүсвэрээр	Өөрийн хөрөнгө	17				
	Дотоодын зээл	18				
	Гадаадын зээл	19				
	Дотоодын хандив, тусламж	20				
	Гадаадын хандив, тусламж	21				
Бусад эх үүсвэр	22					
Төсөвт төвлөрүүлсэн орлогын дүн мөр 23 = мөр (24+30)		23				



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО

Татвар, хураамжийн төрлөөр	НДШ		24	Н1	мянган төгрөг		
	ААНОАТ		25				
	НӨАТ		26				
	ХХОАТ		27				
	Гаалийн татвар		28				
	БННУ Санд төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ		29				
Бусад төрлийн татвар, хураамж			30				
Нийт зардал мөр 31 = мөр (32÷39)			31				
Зардал, төрлөөр	Бичиг захидал		32	Н1	мянган төгрөг		
	Боодол		33				
	Илгээлт		34				
	Буухиа шуудан		35				
	Хэвлэл захиалга (ном, сонин, сэтгүүл)		36				
	Марк, үнэт цаасны борлуулалт		37				
	Хургэлт		38				
	Судалгаа, шинжилгээний ажлын зардал		39				
	Бусад		40				
2. ХҮНИЙ НӨӨЦИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД							
Ажиллагчдын тоо			41	Н2	тоо		
мөр 41 = мөр(42÷51) = мөр (52+53) = мөр (54÷62) = мөр (63÷68) = мөр (69÷78)							
Ажиллагчид, насны бүлгээр	24 хүртэл		42				
	25-29 хүртэл		43				
	30-34 хүртэл		44				
	35-39 хүртэл		45				
	40-44 хүртэл		46				
	45-49 хүртэл		47				
	50-54 хүртэл		48				
	55-59 хүртэл		49				
60-64 хүртэл		50					
65 ба түүнээс дээш		51					
Ажиллагчид, хүйсээр	Эрэгтэй	1	52				
	Эмэгтэй	2	53				
Ажиллагчид, боловсролын түвшнээр	Боловсролгүй	1	54				
	Бага боловсролтой	2	55				
	Суурь боловсролтой	3	56				
	Бүрэн дунд боловсролтой	4	57				
	Техникийн болон мэргэжлийн	5	58				
	Тусгай мэргэжлийн дунд	6	59				
	Дипломын болон бакалавр	7	60				
	Магистр	8	61				
	Доктор	9	62				
Ажиллагчид, мэргэжлийн чиглэлийн индексээр	Шуудан холбооны инженер	061903	63				
	Мэдээллийн технологийн инженер /ИТ/	0613	64				
	Харилцаа холбооны инженер	071406, 071407	65				
	Маркетинг, бизнесийн удирдлага	0413, 0414	66				
	Эдийн засагч, санхүүч, нягтлан бодогч	0411, 0412, 031101	67				
	Бусад	999	68				
Ажиллагчид, албан тушаалаар	Захирал, дэд захирал	1120-53, 1121-49	69	Н1	мянган төгрөг		
	Газар, хэлтсийн дарга, менежер	12, 1349-23	70				
	Инженер техникийн ажилтан	215, 351	71				
	Эдийн засагч, санхүүч, нягтлан бодогч, хуульч	241, 261	72				
	Мэргэжилтэн	242, 2431, 2432, 25	73				
	Шууданч - хургэлтийн ажилтан	4412-11	74				
	Шууданч - жолооч	8322-18	75				
	Ялгагч, хянагч	4412-12, 13, 14	76				
	Үйлчилгээний ажилтан	4211-11	77				
	Бусад		78				

**ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ
ЭЗЭМШИГЧИЙН МЭДЭЭНИЙ (3 - ШҮ) МАЯГТ**

Нийт ажилтнуудын дундаж цалин			79				
Дундаж цалин, албан тушаалаар	Захирал, дэд захирал	1120-53, 1121-49	80	Н1	мянган төгрөг		
	Газар, хэлтсийн дарга, менежер	12, 1349- 23	81				
	Инженер техникийн ажилтан	215, 351	82				
	Эдийн засагч, санхүүч, нягтлан бодогч, хуульч	241, 261	83				
	Мэргэжилтэн	242, 2431, 2432, 25	84				
	Шууданч - хүргэлтийн ажилтан	4412-11	85				
	Шууданч - жолооч	8322-18	86				
	Ялгагч, хянагч	4412- 12,13, 14	87				
	Үйлчилгээний ажилтан	4211-11	88				
	Бусад		89				
3. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД							
Нийт илгээмжийн гардуулалтын тоо, хүргэлтийн төрлөөр <i>мөр 90= мөр (91+100+109+118)= мөр 127</i>			90				
Үйлчилгээний салбар, цэгээр	Гардуулалтын тоо салбар, цэгээр <i>мөр 91= мөр (92÷99)</i>		91	Н2	тоо		
	Улаанбаатар хотод (дүүрэг)	Албаны Хувийн	92 93				
	Аймгийн төвүүдэд	Албаны Хувийн	94 95				
	Сум	Албаны Хувийн	96 97				
	Баг	Албаны Хувийн	98 99				
	Гардуулалтын тоо салбар, цэгээр <i>мөр 100 = мөр (101÷108)</i>		100				
Шуудангийн хайрцгаар	Улаанбаатар хотод (дүүрэг)	Албаны Хувийн	101 102	Н2	тоо		
	Аймгийн төвүүдэд	Албаны Хувийн	103 104				
	Сум	Албаны Хувийн	105 106				
	Баг	Албаны Хувийн	107 108				
	Гардуулалтын тоо салбар, цэгээр <i>мөр 109 = мөр (110÷117)</i>		109				
	Шуудангийн ухаалаг хайрцгаар (Smart box)	Улаанбаатар хотод (дүүрэг)	Албаны Хувийн			110 111	Н2
Аймгийн төвүүдэд		Албаны Хувийн	112 113				
Сум		Албаны Хувийн	114 115				
Баг		Албаны Хувийн	116 117				
Гардуулалтын тоо салбар, цэгээр <i>мөр 118 = мөр (119÷126)</i>		118					
Хаягаар		Улаанбаатар хотод (дүүрэг)	Албаны Хувийн	119 120	Н2	тоо	
	Аймгийн төвүүдэд	Албаны Хувийн	121 122				
	Сум	Албаны Хувийн	123 124				
	Баг	Албаны Хувийн	125 126				



**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО**

Нийт илгээмжийн гардуулалтын тоо, үйлчилгээний төрлөөр <i>мөр 127 = мөр (128÷134) = мөр 90</i>			127					
Шуудангийн үндсэн үйлчилгээ	Бичиг захидал		128	H2	тоо			
	Боодол		129					
	Илгээлт		130					
	Буухиа шуудан		131					
Шуудангийн нэмэлт үйлчилгээ	Хэвлэл захиалга (сонин)		132					
	Ном, сэтгүүл захиалга		133					
	Цахим худалдаа, бараа материал хүргэлт		134					
4. СОЛИЛЦООНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД								
4.1. БИЧИГ ЗАХИДЛЫН СОЛИЛЦОО								
Нийт бичиг захидлын солилцоо <i>мөр 135 = мөр (136÷148)</i>			135					
Энгийн	Улс хооронд	Гарах	136	H1	тоо			
		Орох	137					
		>=70 гр				138		
	Дотоодод	<70 гр				139		
		Орох				140		
		Гарах				141		
Буухиа	Улс хооронд	Орох	142					
		Гарах	143					
	Дотоодод	Орох	144					
		Гарах	145					
Цахим худалдаа	Улс хооронд	Орох	146					
		Гарах	147					
	Дотоодод	Орох	148					
		Гарах	149					
4.2. ИЛГЭЭЛТИЙН СОЛИЛЦОО								
Нийт илгээлтний солилцоо <i>мөр 149 = мөр (150÷161)</i>			149					
Энгийн	Улс хооронд	Гарах	150	H1	тоо			
		Орох	151					
	Дотоодод	Гарах	152					
		Орох	153					
Буухиа	Улс хооронд	Орох	154					
		Гарах	155					
	Дотоодод	Орох	156					
		Гарах	157					
Цахим худалдаа	Улс хооронд	Орох	158					
		Гарах	159					
	Дотоодод	Орох	160					
		Гарах	161					
4.3. БООДЛЫН СОЛИЛЦОО								
Нийт боодлын солилцоо <i>мөр 162 = мөр (163÷174)</i>			162					
Энгийн	Улс хооронд	Гарах	163	H1	тоо			
		Орох	164					
	Дотоодод	Гарах	165					
		Орох	166					
Буухиа	Улс хооронд	Орох	167					
		Гарах	168					
	Дотоодод	Орох	169					
		Гарах	170					
Цахим худалдаа	Улс хооронд	Орох	171					
		Гарах	172					
	Дотоодод	Орох	173					
		Гарах	174					
4.4. БУСАД СОЛИЛЦОО								
Улс хооронд /транзит/	Дамжин өнгөрөх		175	H2	тоо			
	Буцаалт		176					

ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИЙН МЭДЭЭНИЙ (3 - ШҮ) МАЯГТ

5. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД			
Сүлжээний бэлэн байдал	Шуудан хүргэлтийн машины бэлэн байдал	>90.0%	177
	Илгээмжийн гардуулалтын чанар	≥ 95.0%	178
1000 үйлчлүүлэгчид ногдох гомдлын хувь			179
Үйлчлүүлэгчээс ирсэн нийт гомдлын тоо			180
Гомдлын тоо, төрлөөр	Үйлчилгээний ажилтны зан харьцаа		181
	Шуудангийн үйлчилгээний талаар		182
	Бусад		183
Үйлчлүүлэгчийн гомдлыг барагдуулсан дундаж хугацаа			184
Үйлчлүүлэгчийн гомдол барагдуулсан хувь			185

Мэдээллийн нууцлалын тайлбар:

H1-Зөвхөн Харилцаа холбооны зохицуулах хороо өөрийн үйл ажиллагаандаа ашиглана. /Нийтэд мэдээлэхгүй/
H2-Жил тутмын харилцаа холбооны зах зээлийн тайлан боловсруулахад ашиглана.

Мэдээг гаргасан:

(Албан тушаал)

(Овог, нэр)

(Гарын үсэг)

Мэдээг хянасан:

(Албан тушаал)

(Овог, нэр)

(Гарын үсэг)

(Тэмдэг)

20.....оны..... сарын өдөр



**ХҮРГЭЛТИЙН ДАВТАМЖ, ХАМРАХ ХҮРЭЭГЭЭР
ШУУДАНГИЙН СҮЛЖЭЭ БОЛОН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧИЙН МЭДЭЭНИЙ
ХАВСРАЛТ №01**

Он _____ (хагас жил/жилийн эцэс)

1. Улс хоорондын шуудангийн хүргэлтийн давтамж /хоногийн тоог бичнэ/

№	Улсын нэр	Чиглэл	Агаар /хоног/		Газар /хоног/	
			Буухиа шуудан	Ердийн шуудан	Авто зам	Төмөр зам
0	А	Б	1	2	3	4
1	АНУ	Гарах Орох				
2		Гарах Орох				

2. Хот доторх шуудангийн хүргэлтийн давтамж /цагаар бичнэ/

№	Хотын нэр	Техник хэрэгслээр /цаг/		Явганаар /цаг/	
		Буухиа шуудан	Ердийн шуудан	Буухиа шуудан	Ердийн шуудан
0	А	1	2	3	4
1	Улаанбаатар хот				
2					
3					

3. Хот хоорондын шуудангийн хүргэлтийн давтамж /хоногийн тоог бичнэ/

№	Аймгийн төвийн нэр	Чиглэл	Агаар /хоног/		Газар /хоног/	
			Буухиа шуудан	Ердийн шуудан	Авто зам	Төмөр зам
0	А	Б	1	2	3	4
1	Дархан-Уул хот	Гарах Орох				
2	Эрдэнэт хот	Гарах Орох				

4. Сум, хот хоорондын шуудангийн хүргэлтийн давтамж /сумдын тоог бичнэ/

№	Шуудангийн төрөл	1 удаа хүргэх хоногийн тоо	Агаар /сумын тоо/	Газар	
				Авто зам/ сумын тоо/	Төмөр зам /сумын тоо/
0	А	1	2	3	4
1	Буухиа шуудан				
2	Үндсэн шуудан				

5. Багт шуудан хүргэх давтамж /Багийн тоог бичнэ/

№	Шуудангийн төрөл	1 удаа хүргэх хоногийн тоо	Агаар /Багийн тоог бичнэ/	Газар	
				Авто зам /Багийн тоог бичнэ/	Төмөр зам /Багийн тоог бичнэ/
0	А	1	2	3	4
1	Буухиа шуудан				
2	Үндсэн шуудан				

**ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ
ЭЗЭМШИГЧИЙН МЭДЭЭНИЙ (З - ШҮ) ХАВСРАЛТ**

**ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАР ЦЭГИЙН ТОО, ХАМРАХ ХҮРЭЭГЭЭР
ШУУДАНГИЙН СҮЛЖЭЭ БОЛОН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧИЙН МЭДЭЭНИЙ
ХАВСРАЛТ №02**

Он _____ (хагас жил/жилийн эцэс)

1. Улс хоорондын шуудангийн хамрах хүрээ, салбар цэгийн тоо

№	Улсын нэр	Чиглэл	Салбар цэгийн тоо	Тайлбар
0	А	Б	1	2
1	БНСУ	Гарах		
		Орох		
2		Гарах		
		Орох		
...				
	Бүх улсад	Гарах		
		Орох		

2. Дотоодын шуудангийн хамрах хүрээ, салбар цэгийн тоо

№	Хамрах хүрээ	Салбар цэгийн тоо	Тайлбар
0	А	1	2
1	Улаанбаатар хот		
2	Аймгийн төв		
3	Сумын төв		
4	Багт		
	Нийт дүн		



**СОЛИЛЦООНЫ ҮЗҮҮЛЭЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРӨЛ, ЖИНГЭЭР
ШУУДАНГИЙН СҮЛЖЭЭ БОЛОН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧИЙН МЭДЭЭНИЙ
ХАВСРАЛТ №03**

Он _____ (хагас жил/жилийн эцэс)

Солилцооны төрөл	Хамрах хүрээ	Чиглэл		МД	Жингийн хэмжээ, кг
А	Б	В		Г	1
Нийт бичиг захидлын солилцоо мөр 1 = мөр (2:14)				1	
Энгийн	Улс хооронд	Гарах		2	
		Орох		3	
	Дотоодод	Гарах	>=70 гр	4	
			<70 гр	5	
		Орох		6	
Буухиа	Улс хооронд	Гарах		7	
		Орох		8	
	Дотоодод	Гарах		9	
		Орох		10	
Цахим худалдаа	Улс хооронд	Гарах		11	
		Орох		12	
	Дотоодод	Гарах		13	
		Орох		14	
Нийт илгээлтийн солилцоо мөр 15 = мөр (16:27)				15	
Энгийн	Улс хооронд	Гарах		16	
		Орох		17	
	Дотоодод	Гарах		18	
		Орох		19	
Буухиа	Улс хооронд	Гарах		20	
		Орох		21	
	Дотоодод	Гарах		22	
		Орох		23	
Цахим худалдаа	Улс хооронд	Гарах		24	
		Орох		25	
	Дотоодод	Гарах		26	
		Орох		27	
Нийт боодлын солилцоо мөр 28 = мөр (29:40)				28	
Энгийн	Улс хооронд	Гарах		29	
		Орох		30	
	Дотоодод	Гарах		31	
		Орох		32	
Буухиа	Улс хооронд	Гарах		33	
		Орох		34	
	Дотоодод	Гарах		35	
		Орох		36	
Цахим худалдаа	Улс хооронд	Гарах		37	
		Орох		38	
	Дотоодод	Гарах		39	
		Орох		40	
Бусад солилцоо, улс хооронд /транзит/	Дамжин өнгөрөх			41	
	Буцаалт			42	

**ШУУДАНГИЙН СҮЛЖЭЭ БОЛОН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧИЙН МЭДЭЭНИЙ
ХАВСРАЛТ №04**

Он _____ (хагас жил/жилийн эцэс)

ҮНЭ ТАРИФ

Үйлчилгээнд хүчин төгөлдөр мөрдөж байгаа үнэ тарифын мэдээллийг, бүтээгдэхүүн үйлчилгээний төрлөөр хүснэгтээр гаргаж хавсаргана.

ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИЙН МЭДЭЭНИЙ (З - ШҮ) МАЯГТ НӨХӨХ ЗААВАР

Харилцаа холбооны зохицуулах хорооны даргын
2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн
А/93 тоот тушаалын Наймдугаар хавсралт

ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИЙН МЭДЭЭНИЙ (З-ХХ-СИҮ) МАЯГТ НӨХӨХ ЗААВАР

Шуудангийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд шуудангийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллага нь Харилцаа холбооны зохицуулах хорооноос баталсан “Шуудангийн үйлчилгээний зах зээлд шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх журам”-ын 4.3-д заасны дагуу өөрийн үйл ажиллагаатай холбоотой тухайн жилийн тайлан, мэдээг дараа оны 2 дугаар сарын 20-ны дотор, хагас жилийн тайлан, мэдээг тухайн оны 8 дугаар сарын 1-ний дотор маягтад тодорхойлсон үзүүлэлтийн дагуу <http://statistics.crc.gov.mn> хаягаар нэвтэрч, Зохицуулах хороонд ирүүлнэ.

Тайлант хугацаа гэж жилийн эцсийн тайлан, мэдээний хувьд өмнөх оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацааг, хагас жилийн тайлан, мэдээний хувьд тухайн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх хугацааг ойлгоно.

МАЯГТЫН НЭР ТОМЪЁО, ТОВЧЛОЛЫН ТАЙЛБАР

НДШ гэж нийгмийн даатгалын шимтгэлд төлсөн нийт дүнг ойлгоно.

ААНОАТ гэж аж ахуйн нэгжийн орлогын албан татварт төлсөн нийт дүнг ойлгоно.

НӨАТ гэж нэмэгдсэн өртгийн албан татварт төлсөн нийт дүнг ойлгоно.

ХХОАТ гэж хувь хүний орлогын албан татварт төлсөн нийт дүнг ойлгоно.

БНҮҮ сан гэж бүх нийтийн үүргийн санд төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээг ойлгоно.

I. ХАЯГИЙН ХЭСЭГ

Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагын нэр, регистрийн дугаарыг улсын бүртгэлийн гэрчилгээнд тусгагдсанаар товчлохгүйгээр нөхнө. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн оршин байгаа байр, хороо, сум, дүүрэг, аймаг, нийслэлийн нэрийг бичиж, Монгол Улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн кодоос тохирох кодыг тус тус нөхнө.

Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагын утасны дугаар, цахим шуудангийн хаяг болон тайлан, мэдээг хариуцан бөглөх ажилтны овог нэр, албан тушаал, утасны дугаар, цахим хаягийг тус тус нөхнө.

II. ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

БАГАНА:Г ХХЗХ-ны даргын 2022 оны А/335 тоот тушаалаар батлагдсан “Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс мэдээ, тайлан бүрдүүлэх, түгээхэд баримтлах журмын 9,2-т заасны дагуу “Н1- Нууц гэж үзэх ба ийм тэмдэглэл бүхий үзүүлэлтийг Зохицуулах хороо зөвхөн өөрийн үйл ажиллагаанд ашиглана.”, “Н2- Нээлттэй мэдээлэл гэж үзэх ба аж ахуйн нэгжийг дурдаж, нийтэд мэдээлж болно.”



БАГАНА: 1 Тухайн үзүүлэлтийн утгыг нөхнө. Ингэхдээ хэмжих нэгж тус бүрийг нягтлах.

БАГАНА: 2 Тухайн үзүүлэлт тус бүрд нэмэлт тайлбар, тодруулга бичиж тэмдэглэх шаардлагатай тохиолдолд тэмдэглэлийг тусгана.

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Санхүүгийн үзүүлэлт хэсэг нь Дүрмийн сангийн хэмжээ, Нийт орлого, Нийт зардал, Нийт хөрөнгө оруулалт, Нийт төсөвт төвлөрүүлсэн орлого гэсэн дэд хэсгүүдээс бүрдэнэ.

МӨРИЙН ДУГААР: 1 Дүрмийн сангийн хэмжээ нь тайлант хугацааны байдлаар компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ буюу санхүүгийн тайлан дахь өмчийн дүнг бичнэ. *Дүрмийн сангийн хэмжээ нь 2-6 мөрүүдийн нийлбэр дүнтэй тэнцүү байна.*

МӨРИЙН ДУГААР: 2 Төрийн- Төрийн өмчийн, төрийн өмчийн оролцоотой эсхүл төрийн хамтарсан аж ахуйн нэгж бол энд дүрмийн сан дахь төрийн өмчийн тохирох дүнг нөхнө.

МӨРИЙН ДУГААР: 3 Орон нутгийн- Орон нутгийн өмчийн, Орон нутгийн өмчийн оролцоотой эсхүл орон нутгийн хамтарсан аж ахуйн нэгж бол энд дүрмийн сан дахь өмчийн тохирох дүнг нөхнө.

МӨРИЙН ДУГААР: 4 Хувийн, Монгол Улсын- Дүрмийн сан дахь Монгол Улсын хувийн өмчийн дүнг нөхнө.

МӨРИЙН ДУГААР: 5 Хувийн, гадаадтай хамтарсан- Гадаадын аж ахуйн нэгжтэй хамтарсан аж ахуйн нэгж бол дүрмийн сан дахь гадаад талын өмчийн дүнг нөхнө.

МӨРИЙН ДУГААР: 6 Гадаад улсын- Гадаад улсын хөрөнгө оруулалттай бол гадаад улсын өмчийн дүнг нөхнө.

МӨРИЙН ДУГААР: 7 Нийт орлого - Тайлант хугацаанд шуудангийн үйл ажиллагаанаас олсон нийт орлогын дүнг бичнэ. *Нийт орлого буюу 7 дугаар мөрийн дүн нь 8-аас 15 дугаар мөрүүдийн нийлбэр дүнтэй тэнцүү байна.*

МӨРИЙН ДУГААР: 8 Орлого, үйлчилгээний төрлөөр, Бичиг захидал - Бичиг захидлын үйлчилгээнээс олсон орлогын дүн байна.

Захидал гэж тодорхой этгээдэд хаягласан, дугтуйлсан болон дугтуйлаагүй гар бичмэл, хэвлэмэл баримт бичиг агуулсан шуудангийн илгээмжийг ойлгоно. (Шуудангийн тухай хуулийн, 3.1.4)

МӨРИЙН ДУГААР: 9 Орлого, үйлчилгээний төрлөөр, Боодол- Боодлын үйлчилгээнээс орсон орлогын дүнг нөхнө.

Боодол гэж тодорхой этгээдэд хаягласан, эд зүйлс агуулсан битүүмжлэгдсэн шуудангийн илгээмжийг ойлгоно. (Шуудангийн тухай хуулийн, 3.1.5) Боодол, хэвлэмэл материалын хүндийн хэмжээ нь 2кг хүртэл байна. (Шуудангийн үйлчилгээнд тавих шаардлага MNS 6776:2019)

МӨРИЙН ДУГААР: 10 Орлого, үйлчилгээний төрлөөр, Илгээлт- Илгээлтийн үйлчилгээнээс олсон орлогын дүнг нөхнө.

Илгээлт гэж боодлоос овор хэмжээгээр том шуудангийн илгээмжийг ойлгоно.

ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИЙН МЭДЭЭНИЙ (3 - ШҮ) МАЯГТ НӨХӨХ ЗААВАР

(Шуудангийн тухай хуулийн, 3.1.6) Шуудангийн илгээлтийн дээд хязгаар 20 кг хүртэл байна. (Шуудангийн үйлчилгээнд тавих шаардлага MNS 6776:2019)

МӨРИЙН ДУГААР: 11 Орлого, үйлчилгээний төрлөөр, Буухиа шуудан - Буухиа шуудангийн үйлчилгээнээс олсон орлогын дүнг нөхнө.

МӨРИЙН ДУГААР: 12- МӨРИЙН ДУГААР:15 Орлого, үйлчилгээний төрлөөр, Хэвлэл захиалга (ном, сонин, сэтгүүл), Марк, үнэт цаасны борлуулалт, Хүргэлт, Бусад - Тайлант хугацаанд шуудангийн үйлчилгээнээс олсон орлогыг дээрх ангиллын дагуу нөхнө. *Орлого, үйлчилгээний төрлөөр буюу 12-15 дугаар мөрүүдийн харгалзах орлогын дүнг нөхнө.*

МӨРИЙН ДУГААР: 16 НИЙТ хөрөнгө оруулалт - Тайлант хугацаанд шуудангийн үйлчилгээнд оруулсан хөрөнгө оруулалтын дүнг бичнэ. *Нийт хөрөнгө оруулалт буюу 16 дугаар мөрийн дүн нь 17-22 дугаар мөрүүдийн нийлбэртэй тэнцүү байна.*

МӨРИЙН ДУГААР: 23 Нийт төсөвт төвлөрүүлсэн орлого - Тайлант хугацаанд шуудангийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой нийт төсөвт төвлөрүүлсэн нийт орлогын хэмжээг буюу ажиллах хүчний нийгмийн даатгалын шимтгэл (НДШ), ААНОАТ, НӨАТ, ХХОАТ, импортоор орж ирсэн бараа материал, тоног төхөөрөмжийн гаалийн татварын дүн, Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан (БНҮҮС)-д төвлөрүүлсэн хөрөнгө болон бусад төрлийн татвар, хураамжийн нийлбэр дүнг бичнэ. *Нийт төсөвт төвлөрүүлсэн орлого буюу 23 дугаар мөр нь 24-30 дугаар мөрүүдийн нийлбэртэй тэнцүү байна.*

Судалгаа, шинжилгээний ажлын зардал гэж байгууллагын бүх төрлийн үйл ажиллагаа, үйлчилгээний чанарыг сайжруулах, шинээр бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлэх, урт ба богино хугацааны төлөвлөгөө боловсруулахад тусгайлан төсөвлөж зарцуулсан зардлыг ойлгоно.

МӨРИЙН ДУГААР: 31 НИЙТ зардал - Тайлант хугацаанд шуудангийн үйлчилгээтэй холбоотой нийт зардлын дүнг бичнэ. *Нийт зардал 31 дүгээр мөрийн дүн нь 32-40 дүгээр мөрүүдийн нийлбэртэй тэнцүү байна.*

ХҮНИЙ НӨӨЦИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Хүний нөөцийн үзүүлэлт хэсэг нь нийт ажиллагчдын тоо, ажиллагчдыг нас, хүйс, боловсролын түвшин, мэргэжил, албан тушаалаар ангилсан тоо, дундаж цалингийн үзүүлэлтээс бүрдэнэ.

МӨРИЙН ДУГААР: 40 Ажиллагчдын тоо - Шуудангийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаанд оролцож, хөдөлмөр эрхлэлтийн аль нэг статуст хамрагдаж буй нийт ажилтныг хамруулна. Цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд сүүлийн долоо хоногт нэгээс дээш цагаар оролцсон ажиллагчдыг багтаана.

Нийт ажиллагчдын тоо буюу 40 дүгээр мөр нь 41-48 дугаар мөр дэх ажиллагчид насны бүлгээр, 49-50 дугаар мөр дэх ажиллагчид хүйсээр, 51-59 дүгээр мөр дэх ажиллагчид боловсролын түвшнээр, 60-65 дугаар мөр дэх ажиллагчид, ажил, мэргэжлийн ангиллаар, 66-75 дугаар мөр дэх ажиллагчид, албан тушаалаар ангилсан ажиллагчдын тооны нийлбэртэй тус тус тэнцүү байна.

(ОУЦХБ-ын аргачлалын дагуу Full Time Employee – FTE буюу бүтэн цагийн ажилтай



ажилтны тоо байна. Бүтэн бус цагийн ажилтай ажилтнуудыг 8 цагийн ажлын өдрөөр дүйцүүлж, бүтэн цагийн ажилтай ажилтанд шилжүүлж тооцно.

ҮСХ заавар: Нийт ажиллагчдын тоо гэдэгт цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож, хөдөлмөр эрхлэлтийн аль нэг статуст хамрагдаж буй иргэдийг хамруулна. Цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд сүүлийн долоо хоногт нэгээс дээш цагаар оролцсон ажиллагчдыг багтаана.)

Ажиллагчдын мэргэжлийн байдал нь албан тушаалтай хамааралгүй бөгөөд ажилтны эзэмшсэн мэргэжлийн код ангиллын дагуу тоог гаргана.

Албан тушаалын ангиллыг өөрийн байгууллагын бүтэц, ажлын байрны нэршилд дүйцүүлэн ойлгож, бөглөнө.

МӨРИЙН ДУГААР: 79 Нийт ажиллагчдын сарын дундаж цалин гэдэг нь тайлант хугацаанд цалин, хөлс авсан ажиллагчдын тоогоор жигнэсэн нийт цалин хөлс болон тайлант хугацаанд цалин, хөлс авсан ажиллагчдын тооны харьцаа юм.

МӨРИЙН ДУГААР: 80-89 Дундаж цалин, албан тушаалаар - Харгалзах албан тушаалын ажиллагчдын нийт цалинг харгалзах албан тушаалтнуудын тоонд харьцуулж гаргана.

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

МӨРИЙН ДУГААР: 90 Нийт илгээмжийн гардуулалтын тоо, хүргэлтийн төрлөөр - Тайлант хугацаанд шуудангийн үйлчилгээний нийт илгээмжийн гардуулалтын тоог хүргэлтийн төрлөөр нөхөх ба Үйлчилгээний салбар цэгээр, Шуудангийн хайрцгаар, Шуудангийн ухаалаг хайрцгаар (Smart box), Хаягаар гэсэн нийт илгээмжийн хүргэлтийн дүнтэй тэнцүү байна. *Нийт илгээмжийн гардуулалтын тоо, хүргэлтийн төрлөөр буюу 90 дүгээр мөрийн дүн нь 91, 100, 109, 118 дугаар мөрүүдийн нийлбэртэй тэнцүү байна. 90 дүгээр мөрийн дүн 127 дугаар мөрийн дүнтэй ижил байна.*

МӨРИЙН ДУГААР: 91 Нийт гардуулалтын тоо салбар, цэгээр - Тайлант хугацаанд үйлчилгээний салбар цэгээр хүргэсэн шуудангийн илгээмжийн гардуулалтын тооны нийлбэр байна. *91 дүгээр мөрийн дүн нь 92-99 дүгээр мөрийн нийлбэртэй тэнцүү байна.*

МӨРИЙН ДУГААР: 100 Нийт гардуулалтын тоо хайрцгаар - Тайлант хугацаанд хайрцгаар хүргэсэн шуудангийн илгээмжийн гардуулалтын тооны нийлбэр байна. *100 дугаар мөрийн дүн нь 01-108 дугаар мөрийн нийлбэртэй тэнцүү байна.*

МӨРИЙН ДУГААР: 109 Нийт гардуулалтын тоо, ухаалаг хайрцгаар - Тайлант хугацаанд ухаалаг хайрцгаар хүргэсэн шуудангийн илгээмжийн гардуулалтын тооны нийлбэр байна. *109 дугаар мөрийн дүн нь 110-117 дугаар мөрийн нийлбэртэй тэнцүү байна.*

МӨРИЙН ДУГААР: 118 Нийт гардуулалтын тоо, хаягаар - Тайлант хугацаанд хаягаар хүргэсэн шуудангийн илгээмжийн гардуулалтын тооны нийлбэр байна. *118 дугаар мөрийн дүн нь 119-126 дугаар мөрийн нийлбэртэй тэнцүү байна.*

МӨРИЙН ДУГААР: 127 Нийт илгээмжийн гардуулалтын тоо, үйлчилгээний төрлөөр - Тайлант хугацаанд нийт шуудангийн илгээмжийн гардуулалтын тоо нь Шуудангийн үндсэн үйлчилгээ, Шуудангийн нэмэлт үйлчилгээний хүргэлтийн дүнтэй тэнцүү байна. *Нийт илгээмжийн гардуулалтын тоо, үйлчилгээний төрлөөр буюу 127 дугаар мөрийн дүн нь 128-134 дүгээр дүнтэй тэнцүү байна. 127 дугаар мөрийн дүн нь 90 дүгээр мөрийн дүнтэй ижил байна.*

СОЛИЛЦООНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

МӨРИЙН ДУГААР: 135 Нийт бичиг захидлын солилцоо - Тайлант хугацааны дотоод, гадаад шуудангийн бичиг захидлын /энгийн болон баталгаат, буухиа, цахим худалдаа/ орох, гарах нийт солилцооны нийлбэр дүнг бичнэ. *Нийт бичиг захидлын солилцоо буюу 135 дугаар мөрийн дүн нь 136-148 дугаар мөрийн дүнтэй тэнцүү байна.*

МӨРИЙН ДУГААР: 149 Нийт илгээлтийн солилцоо - Тайлант хугацаанд дотоод, гадаад шуудангийн илгээлтийн /энгийн болон буухиа, цахим худалдаа/ орох, гарах нийт солилцооны нийлбэр дүнг бичнэ. *Нийт илгээлтийн солилцоо буюу 149 дүгээр мөрийн дүн нь 150-161 дүгээр мөрийн дүнтэй тэнцүү байна.*

МӨРИЙН ДУГААР: 162 Нийт боодлын солилцоо - Тайлант хугацаанд дотоод, гадаад шуудангийн боодлын /энгийн болон баталгаат, буухиа, цахим худалдаа/ орох, гарах нийт боодлын солилцооны 163 - 174 дүгээр мөрийн дүнтэй тэнцүү байна.

МӨРИЙН ДУГААР: 175 Улс хооронд /транзит/, дамжин өнгөрөх - Тайлант хугацаанд улс хооронд дамжин өнгөрч байгаа шуудангийн илгээмжийн дүнг бичнэ.

МӨРИЙН ДУГААР: 176 Улс хооронд /транзит/, буцаалт - Тайлант хугацаанд дамжин өнгөрсөн шуудангаас буцаалт хийгдсэн шуудангийн илгээмжийн дүнг бичнэ.

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

МӨРИЙН ДУГААР: 177 Сүлжээний бэлэн байдал, Шуудангийн хүргэлтийн машины бэлэн байдал - Тайлант хугацаанд шуудангийн хүргэлтийн машины гэмтэл сааталгүй ажилласан хугацааг нийт ажиллах ёстой хугацаанд харьцуулж гаргана.

МӨРИЙН ДУГААР: 178 Сүлжээний бэлэн байдал, Илгээмжийн гардуулалтын чанар - Илгээмжийн гардуулалтын чанарыг гаргахдаа тайлант хугацаанд хугацаандаа хүргэгдсэн илгээмжийн гардуулалтын тоог нийт илгээмжийн гардуулалтын тоотой харьцуулан гаргана.

МӨРИЙН ДУГААР: 179 1000 үйлчлүүлэгчид ногдох гомдлын тоо - Тайлант хугацаанд үйлчлүүлэгчээс ирсэн нийт илгээмжийн гомдлын тоог тайлант хугацааны нийт илгээмжийн гардуулалтын тоотой харьцуулан 1000-д үржүүлж тооцно.

МӨРИЙН ДУГААР: 180 Үйлчлүүлэгчээс ирсэн нийт гомдлын тоо - Тайлант хугацаанд үйлчлүүлэгчээс ирсэн нийт гомдлын тоо байна.

Гомдлыг тооцохдоо тайлант хугацаанд хүлээн авсан шуудангийн илгээмжтэй холбоотой бүх гомдлыг гомдлын хүчинтэй эсэх, сэдвээс үл хамааран багтаасан



байна. Нэг үйлчлүүлэгч нэг сэдвээр нэгээс илүү гомдол гаргах тохиолдолд гомдлын тохиолдол тус бүрийг тусад нь тоолно. Хэрэв үйлчлүүлэгч одоо байгаа гомдлыг хаахаас өмнө дахин гомдол гаргавал түүнийг тусдаа гомдол гэж үзэхгүй, харин эхний хаагдаагүй гомдлын үргэлжлэл гэж үзнэ.


МӨРИЙН ДУГААР: 181 Гомдлын тоо төрлөөр, Үйлчилгээний ажилтны зан харилцаа - Тайлант хугацаанд ирсэн нийт гомдлоос үйлчилгээний ажилтны зан харилцаатай холбоотой гомдлын тоо байна.

МӨРИЙН ДУГААР: 182 Гомдлын тоо төрлөөр, Шуудангийн үйлчилгээний талаар - Тайлант хугацаанд ирсэн нийт гомдлоос шуудангийн үйлчилгээтэй холбоотой гомдлын тоо байна.

МӨРИЙН ДУГААР: 183 Гомдлын төрлөөр Бусад - Тайлант хугацаанд ирсэн нийт гомдлоос дээрхээс бусад гомдлын тоо байна.

МӨРИЙН ДУГААР: 184 Үйлчлүүлэгчийн гомдлыг барагдуулсан дундаж хугацаа - Тайлант хугацаанд ирсэн Гомдол тус бүрийг барагдуулсан хугацааны нийлбэрийг нийт гомдлын тоонд харьцуулж гаргана.

МӨРИЙН ДУГААР: 185 Үйлчлүүлэгчийн гомдол барагдуулсан хувь - Тайлант хугацаанд нийт барагдуулсан гомдлын тоог нийт гомдлын тоотой харьцуулан гаргана.




СТАТИСТИК ТАЙЛАНГИЙН СИСТЕМД ХЭРХЭН НЭВТРЭХ ВЭ?

СИСТЕМД НЭВТРЭХ



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО




WWW.CRC.GOV.MN цахим хуудасны **Тусгай зөвшөөрлийн цахим систем** дээр дарна уу.

Байгууллагын эрх бүхий ажилтан **тоон гарын үсгийн гэрчилгээ** тэй байх шаардлагатай.


СИСТЕМД НЭВТРЭХ



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО



Бүртгэлгүй бол **"Бүртгүүлэх"** хэсэгт Бүртгүүлсэн үйлчилгээ эрхлэгч **"Нэвэрэх"** хэсэгт дарна.



Байгууллага бүртгүүлэхдээ байгууллагын эрх бүхий ажилтан танилт нэвтрэлтийн Дан системийн **Тоон гарын үсгээр** нэвтрэх цэсээр нэвтрэхэд автоматаар бүртгэгдэнэ.



АЖИЛТАН БҮРТГЭХ



Байгууллагыг төлөөлөх эрх бүхий ажилтан тоон гарын үсэг ашиглах системд нэвтэрснээр ажилтыг бүртгэх эрхтэй болно.

Ажилтан бүртгэх хэсэгт эрх бүхий ажилтны мэдээллийг оруулаад ... Товчийг дарна уу.

Ажилтан бүртгэх хэсэгт эрх бүхий ажилтны мэдээллийг оруулахдаа эрхийн дараах эрхийн тохиргоог хийнэ.

Админ - Системд хэрэглэгч нэмэх, тусгай зөвшөөрлийн хүсэлт, санал гомдол илгээх, төлбөр тооцоо харах, статистик тайлан илгээх

Гомдол, санал – Байгууллагыг төлөөлж гомдол, санал илгээх

Тусгай зөвшөөрөл – ТЗ-ийн шинэ болон сунгалтын хүсэлтийн маягт бөглөн илгээх

Статистик – Статистик тайлан илгээх системд статистик тайлан оруулах

Төлбөр тооцоо – Байгууллагын эзэмшдэг тусгай зөвшөөрлийн төлбөр тооцоог харах

АЖИЛТАН БҮРТГЭХ



Ажилтан бүртгэх хэсэгт бүртгэсэн ажилтны мэдээлэл **Хүсэлтүүд** хэсэгт харагдана.

Байгууллагын ажилтнаар бүртгэх хүсэлт

Танд дараах байгууллагаас хүсэлт ирсэн байна:

Чамд (группа) (P6-408571) хуулийн этгээдээс "Тусгай зөвшөөрөл", "Статистик" эрхтэй

Зөвшөөрөх

Шинэ ажилтан системд нэвтрэхэд **Байгууллагын ажилтнаар бүртгэх хүсэлт** гэсэн хэсгийг **Зөвшөөрснөөр** бүртгэлтэй ажилтны жагсаалтад шилжинэ.